ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2025.02.24 № 73

танай _____-ны № _____-т

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ш.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу "Ус цаг уур, орчны шинжилгээний төв"-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, тайланг төлбөрийн акт, албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитын тайланд тусгагдсан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хугацаанд нь ирүүлнэ үү.

Хавсралт 23 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

422503062

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2025/039/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2025 он	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: Г.Ариунцэцэг Цахим хаяг:Ariuntsetsegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 12
4. АУДИТЫН ТАЙЛАН 16
4.1 Ерөнхий зүйл 16
4.2 Материаллаг байдал 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 17
4.5.1 Завсрын аудитын талаар 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 18
5.1 Зөвлөмж 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУСАХЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
ТШЗ	Төсвийн шууд захирагч

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ Ш.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

2025.02.24 № 26

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

422502093

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**48,924,285.07**	**85,188,417.48**
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	2,872,140.00	5,387,440.00
312	**Банкинд байгаа бэлэн мөнгө**	2,872,140.00	5,387,440.00
3121	**Төгрөг**	2,872,140.00	5,387,440.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,872,140.00	5,387,440.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	46,052,145.07	79,800,977.48
351	**Түүхий эд материал**	31,638,495.07	48,268,529.48
35110	Тусгай зориулалттай материал	31,638,495.07	48,268,529.48
354	**Хангамжийн материал**	14,413,650.00	31,532,448.00
35410	Бичиг хэргийн материал	2,151,000.00	116,000.00
35420	Аж ахуйн материал	19,000.00	14,257,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,850,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	100,000.00	900,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,293,650.00	16,259,448.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**736,571,419.26**	**758,291,521.68**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	736,571,419.26	758,291,521.68
392	**Биет хөрөнгө**	149,110,308.18	169,654,521.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	56,754,425.28	56,754,425.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,728,372.72)	(5,818,491.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	62,767,573.78	62,767,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,462,616.68)	(51,826,656.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	93,996,487.12	156,836,137.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,914,524.38)	(65,510,923.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,332,980.00	11,932,980.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,434,814.94)	(8,346,696.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,945,752.00	23,945,752.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,146,581.28)	(11,079,578.07)
393	**Биет бус хөрөнгө**	587,461,111.08	588,637,000.12
39301	Програм хангамж	583,000.00	2,083,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(323,888.92)	(647,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	587,202,000.00	587,202,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**785,495,704.33**	**843,479,939.16**
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**785,495,704.33**	**843,479,939.16**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	785,495,704.33	843,479,939.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	719,077,507.53	719,077,507.53
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	719,077,507.53	719,077,507.53
512	**Хуримтлагдсан үр дүн**	66,418,196.80	124,402,431.63
51210	Өмнөх үеийн үр дүн	66,418,196.80	66,418,196.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	57,984,234.83
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**785,495,704.33**	**843,479,939.16**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**403,624,922.12**	**721,077,884.47**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**46,440,122.12**	**52,400,398.41**
120	**Нийтлэг татварын бус орлого**	46,440,122.12	52,400,398.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,440,122.12	52,400,398.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	46,440,122.12	52,300,398.41
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**357,184,800.00**	**668,677,486.06**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	356,148,100.00	625,884,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	356,148,100.00	625,884,100.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	1,036,700.00	42,793,386.06
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	33,428,886.06
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	423,500.00	7,280,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	613,200.00	2,084,500.00
131106	Төсвийн урамшуулал		
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**410,135,580.67**	**663,093,649.64**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**410,135,580.67**	**663,093,649.64**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	393,491,507.40	613,696,980.64
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	286,779,854.93	474,168,806.55
210101	Үндсэн цалин	280,974,737.33	431,167,682.19
210102	Нэмэгдэл	-	29,514,124.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,487,000.00
210104	Урамшуулал	5,805,117.60	
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	36,583,786.65	61,055,496.41
210201	Тэтгэврийн даатгал	25,102,820.90	42,135,598.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,893,898.77	4,499,860.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,296,206.16	3,593,697.13
210204	Ажилгүйдлийн даатгал	550,345.61	1,985,273.70
210205	Эрүүл мэндийн даатгал	5,740,515.21	8,841,066.76
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	6,532,250.15	6,453,239.10
210301	Гэрэл, цахилгаан	1,568,060.15	1,489,049.10
210302	Түлш, халаалт	4,964,190.00	4,964,190.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	5,003,945.00	10,707,530.00
210401	Бичиг хэрэг	397,830.00	2,792,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,167,600.00	4,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	609,915.00	747,530.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	156,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	672,600.00	2,027,400.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	21,920,408.15	7,662,916.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,077,208.15	4,484,416.00
210604	Урсгал засвар	843,200.00	3,178,500.00
2107	**Томилолт, зочны зардал**	1,026,000.00	3,726,000.00
210702	Дотоод албан томилолт	1,026,000.00	3,726,000.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	2,239,880.00	6,703,445.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	942,500.00	5,966,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,000.00	94,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	489,500.00	
210807	Газрын төлбөр	610,205.00	523,435.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	33,405,382.52	43,219,547.58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,405,382.52	43,219,547.58
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	16,644,073.27	49,396,669.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	-	7,280,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		7,280,000.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	16,644,073.27	42,116,669.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,644,073.27	42,116,669.00
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**(6,510,658.55)**	**57,984,234.83**
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**(6,510,658.55)**	**57,984,234.83**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**357,284,800.00**	**672,777,486.06**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**100,000.00**	**4,100,000.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**100,000.00**	**4,100,000.00**
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	**100,000.00**	**100,000.00**
1200042	**Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих**	**100,000.00**	**100,000.00**
120009	**Бусад орлого**	**-**	**4,000,000.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**357,184,800.00**	**668,677,486.06**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	**356,148,100.00**	**625,884,100.00**
131001	**Урсгал үйл ажиллагааны санхүүжилт**	**356,148,100.00**	**625,884,100.00**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**1,036,700.00**	**42,793,386.06**
131103	**ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө**	**-**	**33,428,886.06**
131104	**Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө**	**423,500.00**	**7,280,000.00**
131105	**Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого**	**613,200.00**	**2,084,500.00**
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**357,284,800.00**	**634,162,186.06**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**357,284,800.00**	**634,162,186.06**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**340,640,726.73**	**584,765,517.06**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**286,779,854.93**	**477,821,870.05**
210101	**Үндсэн цалин**	**191,408,107.27**	**248,538,010.07**
210102	**Нэмэгдэл**	**60,030,347.66**	**155,583,599.98**
210103	**Унаа хоолны хөнгөлөлт**	**10,248,600.00**	**43,007,000.00**
210104	**Урамшуулал**	**25,056,800.00**	**30,693,260.00**
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**36,583,786.65**	**61,402,432.91**
210201	**Тэтгэврийн даатгал**	**24,983,461.12**	**43,249,267.69**
210202	**Тэтгэмжийн даатгал**	**3,019,300.00**	**4,480,167.78**
210203	**ҮОМШӨ-ний даатгал**	**2,292,231.11**	**2,423,300.00**
210204	**Ажилгүйдлийн даатгал**	**558,216.75**	**2,334,588.17**
210205	**Эрүүл мэндийн даатгал**	**5,730,577.67**	**8,915,109.27**
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**6,532,250.15**	**6,453,239.10**
210301	**Гэрэл, цахилгаан**	**1,568,060.15**	**1,489,049.10**
210302	**Түлш, халаалт**	**4,964,190.00**	**4,964,190.00**
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**5,185,755.00**	**7,975,830.00**
210401	**Бичиг хэрэг**	**467,640.00**	**757,600.00**
210402	**Тээвэр, шатахуун**	**3,267,600.00**	**5,700,000.00**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	609,915.00	747,530.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	156,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	684,600.00	530,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,293,200.00	2,448,000.00
210604	Урсгал засвар	2,293,200.00	2,448,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,026,000.00	3,726,000.00
210702	Дотоод албан томилолт	1,026,000.00	3,726,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,750,380.00	23,453,445.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	942,500.00	22,716,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,000.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	610,205.00	523,435.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,484,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,484,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,644,073.27	49,396,669.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7,280,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	7,280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,644,073.27	42,116,669.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	42,116,669.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	38,615,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	36,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	36,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	36,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	36,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(36,100,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,515,300.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,872,140.00	2,872,140.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,872,140.00	5,387,440.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан **/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,077,507.53	66,418,196.80	785,495,704.33
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,077,507.53	66,418,196.80	785,495,704.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	719,077,507.53	66,418,196.80	785,495,704.33
D08	Тайлант үеийн үр дүн		57,984,234.83	57,984,234.83
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,077,507.53	124,402,431.63	843,479,939.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	674,348,600.00	592,045,517.06	82,303,082.94
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	674,348,600.00	592,045,517.06	82,303,082.94
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	667,068,600.00	584,765,517.06	82,303,082.94
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	519,310,400.00	477,821,870.05	41,488,529.95
210101	Үндсэн цалин	259,240,100.00	248,538,010.07	10,702,089.93
210102	Нэмэгдэл	175,942,400.00	155,583,599.98	20,358,800.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,415,400.00	43,007,000.00	10,408,400.00
210104	Урамшуулал	30,712,500.00	30,693,260.00	19,240.00
210105	Гэрээт ажлын хөлс			-
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	66,921,200.00	61,402,432.91	5,518,767.09
210201	Тэтгэврийн даатгал	47,535,200.00	43,249,267.69	4,285,932.31
210202	Тэтгэмжийн даатгал	4,846,400.00	4,480,167.78	366,232.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,423,300.00	2,423,300.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	2,423,300.00	2,334,588.17	88,711.83
210205	Эрүүл мэндийн даатгал	9,693,000.00	8,915,109.27	777,890.73
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	6,732,100.00	6,453,239.10	278,860.90
210301	Гэрэл, цахилгаан	1,689,800.00	1,489,049.10	200,750.90
210302	Түлш, халаалт	5,042,300.00	4,964,190.00	78,110.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	7,977,600.00	7,975,830.00	1,770.00
210401	Бичиг хэрэг	757,600.00	757,600.00	-
210402	Тээвэр, шатахуун	5,701,600.00	5,700,000.00	1,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	747,700.00	747,530.00	170.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	530,700.00	530,700.00	-
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	38,548,000.00	2,448,000.00	36,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,100,000.00	-	36,100,000.00
210604	Урсгал засвар	2,448,000.00	2,448,000.00	-
2107	**Томилолт, зочны зардал**	3,739,300.00	3,726,000.00	13,300.00
210701	Гадаад албан томилолт			-
210702	Дотоод албан томилолт	3,739,300.00	3,726,000.00	13,300.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	23,840,000.00	23,453,445.00	386,555.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,064,200.00	22,716,000.00	348,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			-
210803	Даатгалын үйлчилгээ	113,600.00	98,010.00	15,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	94,000.00	94,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	43,800.00	22,000.00	21,800.00
210807	Газрын төлбөр	524,400.00	523,435.00	965.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	-	1,484,700.00	- 1,484,700.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,484,700.00	- 1,484,700.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	7,280,000.00	7,280,000.00	-
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	7,280,000.00	7,280,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,280,000.00	7,280,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	629,984,100.00	625,984,100.00	4,000,000.00
1310	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	625,884,100.00	625,884,100.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	625,884,100.00	625,884,100.00	-
120004	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	4,100,000.00	100,000.00	4,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,100,000.00	100,000.00	4,000,000.00
4	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		2,872,140.00	- 2,872,140.00
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**		5,387,440.00	-5,387,440.00

2.5.1 Нэмэлт санхүүжилтийн дансны гүйцэтгэл /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,364,500.00	42,793,386.06	5,571,113.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,084,500.00	35,513,386.06	5,571,113.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	34,660,000.00	29,244,187.86	5,415,812.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,340,000.00	4,184,698.20	155,301.80
2104	Хангамж, бараа материалын зардал	1,135,000.00	1,135,000.00	0.00
210401	Бичиг хэрэг	235,000.00	235,000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	900,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	900,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,500.00	49,500.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,280,000.00	7,280,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,449,000.00	42,793,386.06	7,655,613.94
131103	ЗГНХ,Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,084,500.00	33,428,886.06	7,655,613.94
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	7,280,000.00	7,280,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,084,500.00	2,084,500.00	0.00
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,084,500.00	0.00	2,084,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт, 54 арга хэмжээ бүхий ажил, үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн ажилласан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 87%-тай хэрэгжсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 16-ны А/83 дугаар тушаалаар "Ус цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалаар бүтэц орон тоог ТҮМ-15 албан хаагчтай байхаар баталсан байна. Тайлант онд 2 орон тоо дутуу ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тайлант онд тус байгууллагын дарга, нягтлан бодогч нар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул Ус цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Б/62 дугаартай тушаалаар төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Ш.Мөнгөнцэцэгийг томилсон байна. Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын тушаалаар 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/20 дугаартай тушаалаар Б.Цэнгэлмааг нягтлан бодогчоор томилон ажиллуулж байна..

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/163 дугаар тушаалаар баталсан Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа алба байгууллагын НББББББ-г мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,984.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,872.1	5,387.4	2,515.3
35	БАРАА МАТЕРИАЛ	46,052.1	79,800.9	33,748.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	736,571.4	758,291.5	21,720.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	785,495.7	843,479.9	57,984.1
51	Засгийн газрын хувь оролцоо	785,495.7	843,479.9	57,984.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	785,495.7	843,479.9	57,984.2

Дээрх хүснэгтээс харахад дараах нөлөө бүхий дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна: Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 2,515.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ахмадын сангийн харилцах дансанд мөнгө нэмж төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Бараа материал данс 33,748.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 27,671.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 19,272.2 мянган төгрөгийн материал шилжүүлэн авч, 4,188.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал бүртгэж, 17,382.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн данс 21,720.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 36,100.0 мянган төгрөгийн хөрөнгө, 21,289.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй авсан, 7,550.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэсэн, тайлант хугацааны элэгдэл хорогдолд 43,219.5 мянган төгрөгийг тооцсоноос шалтгаалсан байна.
- Эздийн өмчийн данс нь 57,984.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 499,959.8 мянган төгрөгөөр, зардлыг 499,959.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд нийт 625,984.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 126,04.3 мянган төгрөгөөр төсвийг тодотгож нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 674,348.1 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилт олгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 674,348.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 622,137.4 мянган төгрөг буюу 92,2 хувьтай байгаа нь улсын төсвийн зардлын төсвийг 47,687.7 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71408-80101	625,984.1	583,867.4	42,116.6	93.2%
2	71408-80102	48,364.5	38,270.0	5,571.1	88.4%
Нийт		**674,348.6**	**622,137.4**	**47,687.7**	**92.2%**

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны дансны үлдэгдэл 42,116.6 мянган төгрөг байгаа нь цалин, НДШ-ийн зардлаас 41,436.1 мянга, тогтмол зардлаас 278.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 386.5 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 5,571.1 мянган төгрөг байгаа нь орон тоо дутуу ажилласнаас хэмнэгдэж үлдсэн орон нутагт ажилласны нэмэгдэл цалин хэмнэгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд хийгдсэн судалгаагаар тус байгууллага нь тайлант онд ахмадын санд нэмж 4,000.0 мянган төгрөг төвлөрүүлсэн бөгөөд зарцуулалт 1,484.7 мянган төгрөг байгаа нь байгууллагад харьяалалтай ахмадуудад цагаан сар болон ахмадын баяраар хүндэтгэл үзүүлж тэтгэмж олгосон байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан, 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/-ийн зардлын 22,716.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын 1,484.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 48,364.5 мянган төгрөгийн орлогыг хүлээн авч, 42,793.3 мянган төгрөгийн зарцуулалт тайлагнасан ба давсан орлого болох 2,184.5 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэл 39,000.0 мянган төгрөг, Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 7,280.0 мянган төгрөгийг хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ариунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 1 хувиар буюу 2,975.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 2,082.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар "Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл", 2022 оны А/89 дүгээр тушаалаар "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад материаллаг хэмжээний зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорил хүрээнд Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан орон тооны мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.2, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлж ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 59,605.3 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

1. 2,400.0 мянган төгрөгийн албан томилолтын хуудсыг санхүүгийн баримтад хавсаргаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.
2. Үндсэн хөрөнгөнд 43,693.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгэхдээ аккруэл суурьяар бүртгээгүй, мөнгө шилжүүлснээс хойш 2 сарын дараа бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.
3. Бичиг хэргийн материалын дансанд хангамж, аж ахуйн шинж чанартай 1,891.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 5 дугаар зүйлийн 5.1.4, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.
4. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 2,121.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг /сканер, тог баригч/ хангамжийн материалын дансанд бүртгэж,

дансны ангилал буруу тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.3, 5.1.4, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар 2 дугаар зүйлийн 2.1.4, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.

5. Ахмадын сангийн 4,000.0 мянган төгрөгийн төвлөрүүлэлтийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэж. НББ-д буруу тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.
6. Бараа материалын дансанд 5,500.0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг орлогоор бүртгэж, НББ-д буруу тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	4	416.9	4		100%
Нийт дүн	**4**		**4**		**100%**

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэсэн мэдэгдэл гаргаж өөртөө тушаал гарган 560,000 төгрөгийн тэтгэмж авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 6.6.2 дахь заалтуудыг тус тус зөрчиж байгаа бөгөөд албан ёсны чиглэл, шийдвэрийг үндэслэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,139.8 мянган төгрөгийн 1 зөрчил[1] илэрснийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

5.2.1 Албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

1. Бараа материалтай холбоотой

1.1. Илрүүлэлт: Бичиг хэрэг, аж ахуй, шатахууны тайланд 1,670,440.00 төгрөгийн орлогын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны тайланд 469,424.00 төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бичээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, 20.2.6, мөн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангасан ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийг төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолтын хуудсыг санхүүгийн баримтанд хавсаргаагүй.	1	2,400.0	1	2,400.0			1	2,400.0				
Үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ аккруэл сууриар бүртгээгүй, мөнгө шилжүүлснээс хойш 2 сарын дараа бүртгэсэн.	1	43,693.0			1	43,693.0	1	43,693.0				
Бичиг хэргийн материалын дансанд хангамж, аж ахуйн шинж чанартай хөрөнгө бүртгэсэн	1	1,891.0			1	1,891.0	1	1,891.0				
Үндсэн хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмжийг /скайнер, тог баригч/ хангамжийн материалын дансанд бүртгэж, дансны ангилал буруу тайлагнасан	1	2,121.3			1	2,121.3	1	2,121.3				
Ахмадын сангийн төвлөрүүлэлтийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэж. НББ-д буруу тайлагнасан	1	4,000.0			1	4,000.0	1	4,000.0				
Бараа материалын дансанд бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг орлогоор бүртгэж, НББ-д буруу тайлагнасан	1	5,500.0			1	5,500.0	1	5,500.0				
Дүн	**6**	**59,605.3**	1	2,400.0	**5**	**57,205.3**	**6**	**59,605.3**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бичиг хэрэг, аж ахуй, шатахууны тайланд 1,670,440 төгрөгийн орлогын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны тайланд 469,424 төгрөгийн жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бичээгүй	1 .	2,139.8					1	2,139.8				
Дүн	**1**	2,139.8					1	2,139.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотоод хяналт								
Шилэн дансанд байгууллагын батлагдсан орон тоог мэдээлээгүй.	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн	**2**	**2,139.8**					**2**	**2,139.8**

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв
Байгууллагын РД: 9018557

Аудитын код: ГСА-2025/039/НА-СТА-ТШЗ
Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит
Тайлант хугацаа: 2024.01.01-2024.12.31

төгрөгөөр

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
									Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны бүртгэл										
1	Урсгал зардал	Томиолтын зардал	Улаанбаатар хотод ажилласан 3 албан хаагчийн албан томилолтын хуудсыг санхүүгийн баримтанд хавсаргаагүй	2,400,000	Завсрын аудитаар залруулсан	Залруулсан	Залруулсан	Залруулга	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
2	Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхдээ аккруэл сууриар бүртгээгүй, мөнгө шилжүүлснээс хойш 2 сарын дараа бүртгэсэн.	43,693,000	Завсрын аудитаар залруулсан	Залруулсан	Залруулсан	Залруулга	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
3	Бараа материал	Бараа материалын тодруулга	Бичиг хэргийн материалын дансанд хангамж, аж ахуйн материалын шинж чанартай хөрөнгө бүртгэсэн.	1,891,000	Завсрын аудитаар залруулсан	Залруулсан	Залруулсан	Залруулга	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
4	Үндсэн хөрөнгө	Тодруулга тайлан	Үндсэн хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмжийг /скайнер, тог баригч/ хангамжийн материалын дансанд бүртгэж, дансны ангилал буруу тайлагнасан	2,121,350.	Залруулга	Залруулсан	Залруулсан	Залруулга	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
5	Мөнгөн хөрөнгө	Ахмадын сан	Ахмадын сангийн төлөрүүлэлтийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэж. НББ-д буруу тайлагнасан	4,000,000	Залруулга	Залруулсан	Залруулсан	Залруулга	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
6	Бараа материал	Зардал	Бараа материалын дансанд бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг орлогоор бүртгэж, НББ-д буруу тайлагнасан	5,500,000	Залруулга	Залруулсан	Залруулсан	Залруулга	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
			Алдааны дүн	**59,605,350**						
2. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл										
7	Бараа материал	Бараа материалын тодруулга	Бичиг хэрэг, аж ахуй, шатахууны тайланд 1,670,440 төгрөгийн орлогын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны тайланд 469,424 төгрөгийн жолоочийн тооцооны хуудасны бичилт дутуу.	2,139,864	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
			Зөрчлийн дүн	**2,139,864.00**						
3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл										
8	Дотоод хяналт	Шилэн дансны тухай хууль	Шилэн дансанд байгууллагын батлагдсан орон тоог мэдээлээгүй	-	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн	Зөвлөмж	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
9	Зардал	Тэтгэмж	Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь ашиг сонирхолын зөрчилтэй мэдэгдэл гаргаж өөртөө тушаал гарган 560,000 төгрөгийн тэтгэмж авсан		Анхаарах асуудал	Хүлээн зөвшөөрсөн	Анхаарах асуудал	Анхаарах асуудал	Дарга Ахлах нягтлан бодогч	Ш.Мөнгөнцэцэг, Б.Цэнгэлмаа
			Нийцлийн аудитын дүн	-						
			Нийт алдаа, зөрчлийн дүн	**61,745,214.00**						

Бэлтгэсэн: Аудитор Г.Ариунцэцэг Огноо: 2025.02.10

Хянасан: Аудитын менежер Г.Наранбаяр Огноо: 2025.02.10

Хянасан: :Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Огноо: 2025.0.10

4217144454
УСА0055 9019049

Танилцаж зөвшөөрсөн:

Дарга Ш.Мөнгөнцэцэг Огноо: 2025.02.10

Нягтлан бодогч Б.Цэнгэлмаа Огноо: 2025.02.10